



ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА
Д.ГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.22 № 09/38 УНТ-САГ/2013/18-СНА-ТТЗ.

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Тагнуулын ерөнхий газрын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн хэлтсийн 2012 оны санхүүгийн тайлангаар 2012 оны эхэнд кассын үлдэгдэл 195,2 сая төгрөг, 2012 онд Хөрөнгө оруулалтын барилга захиалагчын албанаас /арилжааны банкинд данстай/ 197,7 сая, 08 дугаар албанаас 178,8 сая, нийт 395,5 сая төгрөгийг орлогод авч тавилга, тоног төхөөрөмж, барилгын ажилд нийт 571,6 сая төгрөг зарцуулсан гэсэн боловч эдгээр гүйлгээний нотлох баримт бүрэн бус, кассын тайланг програмаар, зохих маягтаар гаргаагүй, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулалтыг бэлэн мөнгөөр хийсэн байна.

Мөн Санхүүгийн хэлтэс Хангалт үйлчилгээний хэлтэсээс 2012 оны 12 дугаар сард Автобааз, 08 дугаар алба, Нийслэлийн тагнуулын газар, Үндэсний тагнуулын академи, 5 дугаар хэлтэст нийт 41,0 сая төгрөгийг бэлэн мөнгөний карт ашиглан бэлэн мөнгөөр санхүүжилтийг хийлгүүлсэн нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 5.5-д " төлбөрийн картын дансыг өөрийн орлогыг төвлөрүүлэх, дамжсан гүйлгээ хийх зэрэг төрийн сангийн санхүүжилт авахаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасныг үндэслэн цаашид бусад ТЕГ-ын харъяа байгууллагуудын санхүүжилтийг төлбөрийн карт ашиглан бэлэн мөнгөөр дамжуулан санхүүжүүлэхгүй байх, Санхүүгийн хэлтэст бэлэн мөнгөний касс ажиллуулахгүй байх талаар арга хэмжээ авч зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус Санхүүгийн хэлтсийн даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч Б.Даваахүүд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР**

Л.ОДГЭРЭЛ

ЗӨВШӨӨРСӨН:

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЖЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТЭГЧ

УХА0122

Б.ДАВААХҮҮ

УХА0273